



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/106

Арвайхээр

Газар эзэмшүүлэх тухай

"Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29.2, 29.3 дахь заалт, Монгол Улсын "Газрын тухай" хуулийн 21.4.3 дахь заалт, 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XXI.1.57 дахь хэсэг, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XXI.1.57-д тусгагдсан "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицолын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд "Газрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтанд дурьдагдсан 1 иргэнд 759м² газрыг эзэмшүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны "Газар эзэмших эрх шилжүүлэх тухай" 74 дүгээр захирамжийн Доржийн Лхамсүрэнгийн холбогдох газар эзэмших эрхийг хүчингүйд тооцсугай.

3. Эзэмшилд олгосон газрын захын цэгүүдийг тэмдэгжүүлж, хяналт тавин ажиллах, газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээжүүлэн Улсын бүртгэлд бүртгэхийг Газрын даамал /Ш.Адъяадолгор/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ

371100331

Сумын Засаг даргын 2018 оны
 8 дугаар сарын 11-ны өдрийн 11/166 дугаар
 захирамжийн хавсралт

Иргэдийн эзэмшсэн газрын мэдээллийн өөрчлөлт

Дү	Газар өмчлөгчийн			Өмнөх				Газрын шинэчилсэн мэдээлэл				
	Овог	Нэр	Регистрийн дугаар	Захирамж	Нэгж талбарын дугаар	Хэмжээ м/кв	Нэгж талбарын дугаар	Хэмжээ м/кв	Байршил	Ашиглалтын зориулалт	Хугацаа /жил/	
0	1	2	3	7	8	11	12	13	14	15	16	17
1	Дорж	Лхамсүрэн	ЙЮ63122565	2008	74	140105573	821.93	6216015485	759	4.31.4	ГБХ	19.7